



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭС

2021 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 02 дугаар сарын 04 -ний өдрийн хуралдааны 3 дугаар тэмдэглэлд:


22.ХЭЛЭЛЦСЭН нь:

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсээс хийсэн гүйцэтгэлийн шалгалтын тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5³ дугаар зүйлийн 5³.1 дэх хэсэг, мөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу тус газрын “Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай” тогтоолын биелэлтийг хангуулах зорилгоор доорх төрийн өмчит 10 хуулийн этгээдэд гүйцэтгэлийн шалгалтын үнэлгээгээр 9 байгууллага “Тодорхой үр дүнд хүрсэн”, 1 байгууллага “Эрчимжүүлэх шаардлагатай” байгаа тухай танилцуулав.

Цаашид шалгалтын мөрөөр авах арга хэмжээг эрчимжүүлж, тогтоолын бүрэн хэрэгжээгүй зарим заалтын биелэлтийг ханган ажиллах, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2021 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн А-1/66 дугаар албан бичгээр хүргүүлсэн албан даалгаврыг мөрдөн ажиллахыг гүйцэтгэлийн шалгалтад хамрагдсан “Монголын цахилгаан холбоо” ХК, “Зам тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ, “Диспетчерийн үндэсний төв” ХХК, “Монголын төмөр зам” ТӨХК, “Баруун бүсийн эрчим хүчиний систем” ТӨХК, “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ, “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК, “Монгол-Ус” ТӨҮГ, “Хөвсгөл АЗЗА” ТӨХК, “Аялал жуулчлалын хөгжлийн төв” ТӨҮГ-ын удирдлагуудад даалгав.” гэжээ.



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

13201010

D:\Huraldaanii material\2021 он\2021.02.04 3r huraldaan.docx